



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/50

Бор-Өндөр

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,  
техникийн хяналтын урьдчилсан үзлэг  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны А/144 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, урьдчилсан үзлэгийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичиг:

Татварын Улсын байцаагч

Гишүүд:

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга


2.//

2. Сумын хэмжээнд 3 буюу түүнээс дээш жил үзлэг оношилгоо болон татварт хамрагдаагүй тээврийн хэрэгслийн татварын өрийг гаргаж, тухайн татвар төлөгчтэй холбогдож өрийг төлүүлэх ажлыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Төсөвт байгууллагын авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг тооцоолол болон нэхэмжлэлийн жагсаалтаар тулгаж, өрийг бүрэн төлүүлж дуусахыг татварын албанд даалгасугай.

4. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын урьдчилсан үзлэгт хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ